

APU COMPANY

Absolute. Pure. Unique.



— 2015 —
ЖИЛИЙН ТАЙЛАН



АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ	4-21
Эрхэм зорилго, үнэт зүйлс	
Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын захидал	
Гүйцэтгэх захирлын захидал	
Үйл ажиллагааны хураангуй	
БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	22-38
Стратеги	
Зах зээл, өнөөгийн байдал	
Үйл ажиллагаа	
Шинэ болон шинэчилсэн брэндүүд	
ЗАСАГЛАЛ	39-50
Компанийн засаглал	
Төлөөлөн удирдах зөвлөлийн баг	
Хувьцааны мэдээлэл	
Ногдол ашгийн бодлого	
Гүйцэтгэх удирдлагын баг	
Шагнал	
ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	51-59
Тогтвортой байдлын бодлого	
Хийгдсэн ажлууд	
Эрсдэлийн удирдлага	
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ	60-68
Санхүүгийн тайлан	
НЭР ТОМЪЕОНЫ ТАЙЛБАР	69-70

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид нийгэмд баялаг бүтээх тулгуур хүч нь болж, өөрсдийн гаргасан амжилтаараа хүн, байгаль дэлхий, ирээдүйдээ хувь нэмрээ оруулахад оршино.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ

БИЗНЕС ЭРХЛЭЛТ

Бид бүх шатанд багаар ажиллан хамтран туурвиж, хүмүүсээ зоригжуулан дуудаж, урамшуулан тэтгэн, тэргүүлэгч болохын төлөө эрмэлзэнэ.

ИЛ ТОД БАЙДАЛ

Ил тод байдлыг эрхэмлэн, хийж буй ажилдаа бусдыг татан оруулж, урамшуулахын тулд зорилгоо бүрэн таниулна.


ӨВӨРМӨЦ БАЙДАЛ

Бид тулгарсан сорилт бүрийг даван туулж, хамтран ажилладаг түншүүд, нийгэмдээ дэмжлэг үзүүлэх ухаалаг замуудыг эрэлхийлнэ.

ЧИН ШУДАРГА БАЙДАЛ

Бид хийж байгаа зүйлээ үнэнч шударга, ёс суртахууны сахилга баттай гүйцэтгэж, Монгол улсын байгалийн баялгийг хойч үедээ өвлүүлэн үлдээж, олон улсын стандартуудыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд хөгжүүлэхийн төлөө ажиллана.

ТҮҮХЭН ТОВЧООН



БИДНИЙ БАРИМТЛАЛ

"ТӨГС. ТӨГӨЛДӨР. ТУНГАЛАГ"
ABSOLUTE. PURE. UNIQUE

Монголын уламжлалт нүүдэлчдийн соёл, гүн ухаанд хурмаст тэнгэрийг цэвэр хязгааргүйн билэгдэл, хөвчин дэлхийн онгон байгаль, цаг хугацаа, оюун ухааны хосгүй нэгдэл гэж үздэг. Энэ хоёр ижилгүй шинж нийлэн цэвэр ариун чанарыг он удаан жил хадгалж иржээ. "Төгс. Төгөлдөр. Тунгалаг" гурвалыг "Хамгийн Шилдэг"-ээ дээдлэх Монгол уламжлалаар "Дээж" болгон бид өргөн барьж байна. Энэхүү итгэлийг бид бизнесийнхээ цөм болгон, хийж байгаа бүхнээ улам сайжруулахыг эрмэлздэг. Бидний хөрөнгө оруулалтаар боссон бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бид үйлчлүүлэгч нартаа болон нийгэмдээ зориулан цаг үргэлж боловсронгуй болгохоор зорин ажиллах болно.

ABSOLUTE. ТӨГС

Үүрэг хариуцлага

- Бид хөгжлийг хөтөлж, нийгмийг манлайлан, зах зээл болон хамтрагчаа хүндэтгэж, үндсэн зорилгоо бүрэн таниулна.
- Компанийн санхүү, мэдээллийг ил тод, үйл ажиллагааг тогтвортой байлгана.
- Монголын тэргүүлэгч ажил олгогч байна.

PURE. ТӨГӨЛДӨР

Ёс зүй, орон зай

- Бид хүн, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, үнэт зүйлээ дээдлэнэ.
- Компанийн хөгжил нь үйлдвэрлэлийн шинэ технологи дээр суурилна.
- Бизнесийн ил тод байдал, аюулгүйн нөхцлийг хангаж ажиллана.

UNIQUE .ТУНГАЛАГ

Соёл, бүтээгдэхүүн

- Орчин цагийн зах зээлийг манлайлан тодорхойлж, хүнсний монгол брэндийг бүтээн үйлдвэрлэгч байна.
- Дэлхийн түвшний бизнесийн байгууллагуудтай түншилж, хамтын ажиллагааг өрнүүлнэ.
- Монголын хэл, соёлын өвөрмөц өвийг хадгалан хамгаалж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

2015 он бидний хувь “ТӨГС. ТӨГӨЛДӨР. ТУНГАЛАГ” уриан дор нэгдсэн чадварлаг хамт олон, хэрэглэгчийнхээ итгэл сайшаалыг хүртсэн бүтээгдэхүүний манлайллаа бататгасан жил байлаа. Зах зээлийн амаргүй сорилт үргэлжилсэн энэ хугацаанд нийт хувьцаа эзэмшигч, хэрэглэгч, харилцагч, хамтран ажиллагч, түнш болон нийт ажилчин, албан хаагч та бүхний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа нэр төртэй биелүүлэх нь бидний үндсэн зорилго юм.

Үйлдвэрлэлийн өндөр бүтээмжтэй, өртөг зардал багатай, байгаль орчинд ээлтэй нэгдсэн системийг улам бүр сайжруулах замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлэн, эцсийн хэрэглэгчийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүний брэндийн цогц бодлогыг хэрэгжүүлж, хүн төвтэй байгууллагын тогтвортой хөгжлийн стратегийг баримтлан ажилласны үр дүнд АPU company-н санхүүгийн гүйцэтгэл 2014 онтой харьцуулахад эерэг үзүүлэлттэй гарлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцаанд 70 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн нь Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниуд дундаас хамгийн тогтвортой, өсөлттэй

ногдол ашиг тарааж ирсэн түүхийн үргэлжлэл байлаа. Түүнчлэн, хөрөнгийн зах зээл дээрх хувьцааны эрэлтийг хангах, эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор нэгж хувьцааг 10 хуваах санал дэвшүүлж байгаа нь компанийн зах зээлийн үнэлгээг өсгөх, хувьцааны арилжааг нэмэгдүүлэх зэргээр хувьцаа эзэмшигч бүрт эерэг үр дүн өгөх нь дамжиггүй тул та бүхэн уг саналыг дэмжинэ гэдэгт итгэлтэй байна.

2016 онд эдийн засгийн хүндрэл үргэлжилж, АPU company-н өмнө цөөнгүй сорилт тулгарч болзошгүй байгаа тул өнөөгийн нөхцөл байдалд бид оновчтой, үр өгөөжтэй стратегийн томоохон шийдлүүдийг эрэлхийлж, нийгмийн хариуцлагатай, бизнесийн тогтвортой хөгжлийг бүрдүүлэхийн төлөө зорин ажиллах болно.

Ийнхүү АPU company-н хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэн, бидний сэтгэл зүрхээ шингээсэн брэнд, бүтээгдэхүүний үнэнч хэрэглэгч, АPU company-н бизнесийн хариуцлагатай ёс зүйг нийгэмд түгээн дэлгэрүүлэгч элч болж, манай хамт олны хүчин чармайлтыг ямагт дэмжиж байгаад тань энэ ялдамд гүн талархал илэрхийлье.

АPU COMPANY-Н ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Пүрэвийн БАТСАЙХАН



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түнш байгууллагууд болон компанийн нийт ажилчид та бүхний энэ өдрийн амар мэндийг эрэн мэндчилье,

Юуны өмнө өнгөрсөн 2015 онд АPU company нь ололт амжилтаа бататган, 883 ажилтан, ажиллагсдынхаа хичээл зүтгэл, хөдөлмөрийн үр дүнд салбартаа тэргүүлэгчийнхээ байр сууриа хадгалж, эдийн засагт өөрсдийн хувь нэмрээ бодитойгоор оруулсан гэдгийг хэлэх нь зүйтэй.

Бид өөрсдийн туршлага дээрээ үндэслэж ёс зүйн хэм хэмжээгээ баримталж, соёлыг төлөвшүүлэн бүтээгдэхүүн бүртээ чанар аюулгүй байдлыг эрхэмлэх зорилтуудыг дэвшүүлэн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, улмаар ашигт ажиллагааг сайжруулахад гол анхаарлаа хандуулан зах зээлд эзлэх хувийг оновчтой төвшинд барьж, банкны зээлийн эргэн төлөлтийг ханган ажиллалаа.

Хэдийгээр улс орны эдийн засгийн өсөлт саарч, хэрэглээний зах зээл агшиж, эдийн засгийн хувьд хүндхэн жил байсан ч бид үйл ажиллагаагаа тогтвортой байлгахыг зорьж, нийгмийн хариуцлагаа ухамсарлан, ажилчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, хүнсний эрүүл аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, үйлдвэрлэлдээ шинэ санал санаачилга, бүтээлч ажлуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж чадсан билээ. Үүний үр дүнд "Дээж", "Сэрүүн", "Альфа" брэндүүдийг зах зээлд шинээр гаргаж "Сайн", "Болор", "Оргилуун", "ARKHI" брэндүүдийнхээ нэр төрлийг нэмэгдүүлж, улмаар 116 нэр төрлийн 94 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж,

327 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн төдийгүй 11,2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, улсын төсөвт 124 тэрбум төгрөгийн татварыг төлсөн. Түүнчлэн нэгж хувьцааны ханш 2015 оны эхэн үетэй харьцуулахад оны эцэст 4%-р өссөн үзүүлэлттэй байж, бид олон улсын банк, санхүүгийн байгууллагад нийт 19,7 сая долларын эргэн төлөлтийг гүйцэтгэн, үйлдвэрлэлдээ 4,5 тэрбумын хөрөнгө оруулалтыг хийлээ.

Цаашлаад бид бизнес процессыг стандартчилж, мэдээллийн урсгалыг сайжруулан, ажилчдынхаа хувь хүний хөгжил, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт ажлуудыг хэрэгжүүлэн 2016 онд АPU company 873 ажилчинтайгаар 150 гаруй нэр төрлийн 104 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 351 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийхээр зорилго тавин ажиллаж байна. Мөн олон улсын банк, санхүүгийн байгууллагад нийт 16 сая ам.долларын зээлийн эргэн төлөлтийг гүйцэтгэж, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй, тогтвортой явуулж, компанийн үйл ажиллагааны стратегийн хүрээнд хэмнэлтийн горимд ажиллах зэрэг зорилтуудыг төлөвлөж байгаа билээ.

Эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч болон энэхүү өнөр өтгөн гэр бүлийн гишүүн та бүхнийг бидэнтэй хамт хөгжил дэвшил өөд урагшилж, Монгол улсын хүнсний салбарын ууган үйлдвэрлэгч АPU company-тай хамтран ажиллаж буйд талархаж, ирээдүйд илүү үр ашигтайгаар, хамтын ажиллагаагаа улам бүр нэмэгдүүлэн ажиллана гэдэгт итгэлтэй байна.

APU COMPANY-Н
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ


2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ


ЦЭВЭР БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (сая.төгрөг)

210,111




БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ (мян.литр)

90,606




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (сая.төгрөг)

27,258




ЦЭВЭР АШИГ (сая.төгрөг)

11,187




БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР ТӨРӨЛ (SKU)

116



НИЙТ АЖИЛЧДЫН ТОО

883



2015 ОНЫ ҮР ДҮН БОЛ БИДНИЙ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОВЧТОЙ БАЙДАЛ, БОДЛОГЫН ҮР ДҮН ЮМ.

ОРЛОГО ҮР ДҮН		2015	2014	ӨӨРЧЛӨЛТ
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	210,111	198,469	6%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	27,258	6,233	337%
Цэвэр ашиг	сая.төг	11,187	(14,174)	-179%

БАЛАНС

Нийт хөрөнгө	сая.төг	307,662	337,424	-9%
Нийт өр төлбөр	сая.төг	161,545	205,867	-22%
Нийт эздийн өмч	сая.төг	146,117	131,556	11%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	307,662	337,424	-9%

МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	40,324	17,591	129%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(4,486)	(19,190)	-77%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(39,022)	(17,290)	126%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(3,184)	(18,888)	-83%

ТАТВАР ТӨЛӨЛТ

ОАТ	сая.төг	90,790	123,023	-26%
НӨАТ	сая.төг	19,274	17,279	12%
Бусад	сая.төг	14,599	9,006	62%
Нийт		124,662	149,308	-17%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


Төслийн хөрөнгө оруулалт	сая.төг	4,160	27,198	-85%
Үйл ажиллагааны хөрөнгө оруулалт	сая.төг	326	752	-57%
Нийт	сая.төг	4,486	27,950	-84%

Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 12 сарын байдлаар 5.9 их наяд төгрөг байсан ба үүний 5.1 их наяд төгрөг татварын орлогоос, түүний 1.2 их наяд төгрөг онцгой албан татвараас төвлөрсөн, үүнээс АРУ Company нь татварын орлогын 2%, Онцгой албан татварын 15%-ийг бүрдүүлсэн байна.

ТАТВАР ТӨЛӨЛТ

Компанийн нийгмийн хариуцлага бол бизнес болон хүрээлэн буй орчинд эерэг байх арга замаар компанийн ажилчид, тэдний гэр бүл, тухайн орон нутгийн иргэдийн амьдралыг сайжруулахын тулд тогтвортой эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах бизнесийн үүрэг юм. Тэгвэл АРУ company нь сүүлийн 5 жил-ийн турш нийт 613 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүллээ.

613 ТЭРБУМ ТӨГРӨГ



Эх сурвалж: Сангийн яам, 2015 оны 12-р сарын хураангуй

ТӨСӨЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ШАР АЙРАГНЫ ҮЙЛДВЭР



НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ
**48.7 ТЭРБУМ
ТӨГРӨГ**

ХҮЧИН ЧАДАЛ
45-50 САЯ ЛИТР

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
KRONES AG, ГЕРМАН

НИЙТ ОРОЛЦСОН
АЖИЛЧИД **1000**

Бид 48,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шингэн хүнсний тоног төхөөрөмж үйлдвэрлэлтээр дэлхийд тэргүүлэгч KRONES компанийн хамгийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, шар айрагны үйлдвэрийн өргөтгөлийг 2012 онд эхлүүлэн барьж 2013 оны 8-р сард анхны чаналгаа хийн ашиглалтанд хүлээн авсан. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр бид үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг 90 сая литр болгож бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмэгдүүлснээс гадна байгальд ээлтэй үйлдвэрлэл эрчим хүч, ус, уурын хэрэглээг багасгаж, хог, хаягдлыг бууруулж чадлаа.

ТӨСӨЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ЛОЖИСТИК ТӨВ



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
30 ТЭРБУМ

ХҮЧИН ЧАДАЛ
ТАЛБАЙ
3,000 М²

ЭЗЛЭХҮҮН
96,000 М³

ТАВИУР
11 ДАВХАР

КРАН
3 ШИРХЭГ

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
KRONES AG, ГЕРМАН

НИЙТ ОРОЛЦСОН
АЖИЛЧИД
796

Монголын эдийн засаг хурдтайгаар өсч, хүн амын худалдан авах чадвар нэмэгдэхийн хэрээр бид зах зээл, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн ажилласаар ирсэн. Үйлдвэрлэл, борлуулалтын тоо хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж бэлэн бүтээгдэхүүний агуулахын хэрэгцээ шаардлага, бүтээгдэхүүн тус бүрийн онцлогт тааруулсан хадгалалтын горим, орчин үеийн техник технологи, програм хангамжийг борлуулалтын системд нэвтрүүлэх зорилгоор 2012 онд Бүрэн автомат Ложистик төвийн төслийг эхлүүлэн 2013 онд хүлээн авснаар Монгол улсын Хүнсний аюулгүй байдалд дэвшил авчирсан. Энэхүү бүтээн байгуулалтанд нийт 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, төслийн үр дүнд бид бүтээгдэхүүний онцлогт тааруулан төвлөрүүлэн хадгалах системийг бүрдүүлж, бүтээгдэхүүний захиалгыг онлайнгаар авах боломжтой болсон.

ТӨСӨЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
45,6 ТЭРБУМ
ТӨГРӨГ

ХҮЧИН ЧАДАЛ
НИЙТ
45 САЯ
ЛИТР/ЖИЛ

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
TETRA PAK, ШВЕД
ECOLEAN 1, ШВЕД
ECOLEAN 4, ШВЕД
ELO PAK
CUPFILLER
GEA GERMANY

НИЙТ ОРОЛЦСОН
АЖЛЧИД
822

Нийслэлийн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэх зорилгоор сүүний үйлдвэр нь 2014 онд фермийн тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг болон Швед улсын Tetra Pak, Ecolean савлах шугам, Япон улсын Elorak, EHEDG буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан, бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хамгийн сүүлийн үеийн үйлдвэр юм.

Жилд 45 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай сүүний үйлдвэрийн боловсруулах хэсэг нь өдөрт 150 тонн бүтээгдэхүүн боловсруулдаг.

Хүнсний Аюулгүй Байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг бүрэн хангаж батламжаа авсан сүүний үйлдвэр нь 300 гаруй фермерүүдээс үнээний шингэн цэвэр сүүг тухайн бүс нутгаас тогтвортой үнээр худалдан авдаг.

ШИНЭ ӨНГӨ ТӨРХ

APU company-н үйл ажиллагааны цар хүрээ өдрөөс өдөрт тэлж, үүний сацуу тус компанийн нийгэмд эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр өсч, бүтээгдэхүүнүүд нь хэрэглэгчдийн шалгуур, чанарын өндөр түвшинд хүрсэн нь бүтээгдэхүүнүүдийн бие даасан брэндиг хийх шаардлага, бололцоог бий болгож байна.

Түүнчлэн APU company нь нийгэмд бүтээж буй баялаг, түүнээс хүртсэн үр шимийг нийгэм, ирээдүйдээ зориулах эрмэлзэл, хариуцлагыг ухамсарлаж, нийгмийн хариуцлагаараа үлгэр жишээ байгууллага болох зорилт тавин ажилласаар ирсэн. Энэ уламжлалаа билэгдэн компанийн өнгө төрхийг өнөөгийн цаг үе, зорилгодоо уялдуулан шинэчлэх болж, 90 жилийн түүхт ойгоороо Архи, Пиво, Ундаа

гэж илэрхийлэгдэж байсан АПУ нэрээ Absolute. Pure. Unique буюу Төгс. Төгөлдөр. Тунгалаг-ийн товчлол АПУ гэж өөрчлөн өнгө төрхөө шинээр тодорхойллоо.

Absolute-Төгс-Үүрэг хариуцлага,
Pure-Тунгалаг -Соёл бүтээгдэхүүн,

Unique-Төгөлдөр ёс зүй орон зайгаа бид үнэт зүйлээ хэмээн үзэж бизнесдээ ил тод, чин шударга зарчмыг баримтлан хэрэглэгчиддээ шинэ, шинэлэг болон олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэн зах зээл болон хамтрагчаа хүндэтгэж, үндсэн зорилгоо бүрэн таниулахаар зорин ажиллаж байна.



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СТРАТЕГИ

2015 онд бид үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг дэвшүүлж ажилласан.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВИЙГ
ОНОВЧТОЙ ТҮВШИНД БАРИХ



БИЗНЕС ПРОЦЕССИЙГ
СТАНДАРЧЛАХ



МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ

Дээрх зорилтуудад хүрэхэд дараах стратегиудыг баримтлан ажиллалаа.



САНХҮҮГИЙН
БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Үр ашигт байдалд чиглэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, бүх түвшний үйл ажиллагаан дахь хэмнэлтийн стратеги

Зах зээлд эзлэх хувиа хадгалах болон нэмэгдүүлэх замаар борлуулалтын орлогын өсөлтийг бий болгох стратеги



ХЭРЭГЛЭГЧ БА
МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ

Брэндийн цогц бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэнд мониторинг хийж тогтвортой байдлыг хадгалах стратеги

Эцсийн хэрэглэгчдэд брэндийн бодлогын баримт бичгийн дагуу олон хувилбарт маркетингийн техникүүдийг ашиглан брэндийг зөв таниулах стратеги



БИЗНЕС ПРОЦЕССИЙН
БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Процесс дээр суурилсан удирдлагын тогтолцоо бүхий оновчтой орон тоо бүтэц зохион байгуулалттайгаар, бага цаг хугацаа зарцуулж, бүтээмжтэй, зардал багатай үйлдвэрлэлийн нэгдсэн систем нэвтрүүлэх стратеги

Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл мөн ашиглалтын зардлыг бууруулах зорилгоор цэвэр ус болон эрчим хүчний зарцуулалтын хэмжээг бууруулан, үйлдвэрлэлд ашигласан усыг дахин ашиглан ажиллах стратеги




ХҮНИЙ НӨӨЦИЙН
БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Ажилтны бүтээмжид нөлөөлөх байгууллагын соёлын орчин, байгууллагын сэтгэл зүй, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлж, чадварлаг хүний нөөцийг дотоод болон гадаад орчинд сургаж хөгжүүлэн бүтээмжийг дээшлүүлэх стратеги

Байгууллагын нэгдсэн зорилго зорилтонд хүрэхийн тулд бизнесийн нэгж бүрийн удирдлага, дунд болон дээд шатанд манлайллыг түгээх, ажилчдыг идэвхижүүлэх, мэдээлэлийн урсгалыг сайжруулах стратеги

ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

СҮҮНИЙ БИЗНЕС



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн нийт сүүний 62%-ийг Европын холбоо, АНУ тэргүүтэй орнууд үйлдвэрлэж байна. Европын Холбоо дэлхийн нийт савласан сүүний 18%-ийг бүрдүүлж байгаа бол АНУ 12%, Энэтхэг 8%, БНХАУ 5%, ОХУ, Бразил тус бүр 4%-ийг бүрдүүлэн удаах байруудыг эзэлжээ. Дэлхийн сүүний гарцын өсөлтөнд хөгжингүй орнуудын гарцын өсөлт чухал нөлөөтэй. 2011-2015 оны хооронд Хятад улсын сүүний гарц 22%, Энэтхэг 19%, Шинэ Зеланд 17%, Бразил 12%-иар тус тус өсчээ.

Монгол улсын үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл 2009-2014 оны хооронд жилд дунджаар 15 хувийн өсөлт үзүүлсэн. Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл нь ийнхүү өндөр өсөлттэй

гарч байгаа нь монголчуудын хэрэглээ уламжлалт хэрэглээнээс орчин үеийн хэрэглээ рүү шилжиж байгаатай салшгүй холбоотой. Чанарын шаардлага хангаагүй задгай сүүнээс илүүтэйгээр үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан хүнсний аюулгүй байдал бүрэн хангасан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэх хандлагатай байгаа юм.

APU company нь 2006 онд "Цэвэр сүү" брэндийг зах зээлд нэвтрүүлж, 2014 онд сүүний шинэ үйлдвэрээ нээснээр Монголын сүүний зах зээлд томоохон хөрөнгө оруулалт, ноу-хау, олон улсын туршлага стандартуудыг нэвтрүүлсэн. Энэхүү хөдөлмөрийн дүнд APU company Монголын сүүний зах зээлийн 19%-ийг нийлүүлж байна.

БРЭНД ХӨГЖҮҮЛЭЛТ БА ИННОВАЦИ

Дэлхийн тэргүүлэгч компаниудтай хамтран ажиллаж, туршлага солилцон Монголынхоо хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ, шинэлэг бүтээгдэхүүнийг хөгжүүлэх нь бидний зорилго билээ.

Өнөөдөр APU company 300 гаруй фермерээс үнээний цэвэр сүүг 12 цэгээр татан авч, боловсруулалт хийн 4 брэндийн 24 нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ хүргэж байна.

САЙН

"Сайн" брэнд 2014 онд анх зах зээлд сүү, бифидо тараг, гүзээлзгэнэтэй йогурт, чангаанзтай йогурт, ойн жимст йогурт, зөөхий зэрэг зургаан төрлийн хадгалах хугацаа богинотой бүтээгдэхүүн танилцуулсан. Брэндийг байгаль орчинд сөрөг нөлөө хамгийн багатай эколин савлагаанд савласан нь APU Company нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын нэг хэсэг юм. 2015 онд йогуртны төрлийг нэмэгдүүлэн интоор, олон жимст, хадны амтаар хэрэглэгчдийн сонголтыг улам баяжуулснаас гадна хаана ч хэзээ ч хэрэглэх боломжтой аяган савлагаанд савлан худалдаанд гаргалаа.

МААМУУ

"Маамуу" брэнд нь хүүхдэд зориулсан Монголын анхны брэнд бүтээгдэхүүн юм. Анх 1970-аад онд APU company "Маамуу" нэрийн дор луувангийн шахмал шүүс шилэнд савлан худалдаанд гаргаж байсан түүхтэй. Тухайн үед тээвэрлэлтийн систем боловсронгуй төвшинд хөгжөөгүй учраас "Маамуу" луувангийн шүүсний үйлдвэрлэл удаан үргэлжлээгүй ч 2014 онд APU company "Маамуу" брэндийг дахин сэргээж хүүхдийн өсөлт, эрүүл мэндэд тустай сүү, шүүс, йогурт үйлдвэрлэж эхэлсэн. Хүүхдийн өсөлт, яс болон шүдний бэхжилтэд сайн кальцийг агуулсан төдийгүй сахарын агууламж багатай, хамгийн сайн чанарын жимсний чанамал, сүүгээр үйлдвэрлэсэн учирээг, эхчүүдийн талархлыг хүлээсэн бүтээгдэхүүн болсон юм. "Маамуу"-гийн баатрууд нь үндэсний хэв маягийг агуулахаас гадна хүүхдүүдийн хүмүүжил, төлөвшилд зэргээр нөлөөлөхүйц агуулгатай учраас бид маркетингийн болон идэвхижүүлэлтийн төрөл бүрийн хөтөлбөрөөрөө дамжуулан хүүхдийн мэдлэг боловсролд хэрэгтэй мэдээллийг өгсөөр байна.

ДЭЭЖ

"Дээж" нь 2015 оны 10-р сард шинээр зах зээлд гарч хэрэглэгчдийн дунд амт чанар, хэрэглэхэд эвтэйхэн савлагаагаараа танигдсан брэнд юм. Одоогоор APU company "Дээж" нэрийн дор ариутгасан сүү болон тараг үйлдвэрлэж байгаа бөгөөд цэвэр үнээний сүүг өргөн амсартай, онгойхдоо асгардаггүй, тогтвортой цаасан савлагаанд савласан нь бүтээгдэхүүний давуу тал болоод байна. Тарагны хувьд ямар ч чихрийн агууламжгүй өтгөн, цөцгий амттайн дээр тослог багатай учраас эмэгтэйчүүд болон эрүүл мэнддээ анхаардаг хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн болоод байгаа билээ.

ЦЭВЭР СҮҮ

"Цэвэр сүү" нь 2006 онд зах зээлд гарснаасаа хойш хэрэглэгчдийн талархлыг хүлээсээр олон тооны үнэнч хэрэглэгчтэй болсон тэргүүлэгч брэндүүдийн нэг юм. Тослог сайтай, өтгөн сүүг таашаадаг монголчуудын хувьд "Цэвэр сүү" нь сүүтэй цай, хийцтэй цай зэрэг үндэсний хоол, цайнд дээд зэргээр нийцнэ. Сайн чанарын сүүг Ultra High Temperature буюу 130 градусын хэмд боловсруулж дэлхийд алдартай Тетрапак савлагаанд савласнаар "Цэвэр сүү" бий болдог. Сүүлийн үед кофены хэрэглээ нэмэгдэж хэрэглэгчдийн завгүй амьдралын хэмнэлийн салшгүй нэг хэсэг болсон. Алдартай баристанууд "Цэвэр сүү"-г латте болон капучино зэрэг сүүний нэмэлттэй кофенд хамгийн сайн тохирох сүүгээр онцолдог. Өөрийн давтагдашгүй чанар, брэндийн нэр хүндийн зэрэгцээ "Цэвэр сүү" нь Монгол улсын 21 аймагт түгээгддэг учраас Монгол орны аль ч өнцгөөс "Цэвэр сүү"-г худалдан авах боломжтой юм.

ШАР АЙРАГНЫ БИЗНЕС



ПИВОНЫ ЗАХ ЗЭЭЛ

Нийгэм эдийн засгийн өөрчлөлт болон хэрэглэгчдийн хэрэглээний чиг хандлага зэргээс улбаалан шар айрагны борлуулалт 2014 онд 188.81 тэрбум литр байсан бол 2015 онд 2%-аар өсөн 192.6 тэрбум литрт хүрсэн байна.

Бүс нутгаар нь авч үзвэл Ази, Номхон далайн шар айрагны хэрэглээ их хэмжээгээр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт зах зээлийн 34.8%-г эзэлж, БНХАУ шар айрагны нийт хэрэглээгээр тэргүүлж байна.

2000 оны эхэн үед импортын пивонууд дотоодын зах зээлийн дийлэнхийг бүрдүүлж байсан бол 2015 оны байдлаар эсрэгээрээ болж өөрчлөгдөн байна.

Дотоодын пивоны үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетинг ПР эрчимтэй хөгжиж, өрсөлдөөн улам бүр ширүүссээр байна.

Дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөөн, түүний үр дүнд бий болж буй бүтээгдэхүүн үйлчилгээ сайжрахын хэрээр гадны брэнд, импортлогчдод үлдэх орон зай улам бүр багассаар байна. 2015 оны гүйцэтгэлээр дотоодын пивоны зах зээлд 16%-ийг импорт бүрдүүлж байна. Энэ үзүүлэлт цаашид улам бүр буурах үндэслэл бий. Учир нь АPU Company 2013 онд шинэ пивоны үйлдвэр ашиглалтад оруулсанаар жилд 90 сая.литр пиво үйлдвэрлэх хүчин чадалтай болсноор бусад үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг нэмж үзвэл нийт зах зээлийн багтаамжаас давсан үзүүлэлт бий болж буй юм. Өөрөөр хэлбэл дотоодын пивоны үйлдвэрлэлийн хүчин чадал зах зээлийн эрэлтийг хангах бүрэн боломжтой болсон. Өнөөдрийн байдлаар АPU company дотоодын шар айрагны зах зээлийн 55%-ийг хангаж байна.

БРЭНД ХӨГЖҮҮЛЭЛТ БА ИННОВАЦИ

APU company нь зах зээлийг тэргүүлэгчийн байр сууриа эрхэмлэн, хэрэглэгчдийн хэрэглээг чиглүүлэх, тэдэнд дэлхийн чиг хандлагын инновацийг Монголынхоо онцлогт тохирсон хэлбэрээр нэвтрүүлэн ажиллаж байна. Бүтээгдэхүүний гадаад үзэмж болон бүтээгдэхүүн нь хамгийн шилдэг, хамгийн чанартай байх, хэрэглэх сэдлийг төрүүлж, хэрэглэгчдийн санаанд нийцүүлж байх нь бидний зорилго билээ.

БОРГИО

Монголын шар айрагны түүхийг эхлүүлэгч, Монголын хэрэглэгчдийн эртний танил, №1 "Боргио" брэнд нь анх 1927 онд үйлдвэрлэгдэж эхэлсэн бөгөөд 1940-д оноос "Боргио" гэдэг нэрээр олны танил болсон байдаг. Сонгодог Герман технологиор үйлдвэрлэгддэг уг брэнд нь сонгодог лагер төрлийн шар айрагны амтыг илтгэх бөгөөд зөрөг цэцэг ба арвайн соёолжны гайхалтай тэнцлийг мэдрүүлэх чимчигнэсэн амтыг мэдрүүлдэг. "Боргио" брэндийн гайхалтай амт нь гагцхүү Монголын хэрэглэгчид төдийгүй дэлхийд алдартай World Beer Awards шагналаас 2011 онд Дэлхийн шилдэг лагер пиво гэдэг шагналыг хүртсэн билээ.

СЭРҮҮН

"Сэрүүн" Light – шинэ үеийн шар айраг хэрэглэгчид, шинэ үеийн залуусын хэрэглээг илэрхийлэх энэхүү жинхэнэ зөөлөн / LIGHT шар айргийг АPU company нь 2015 оны 5-р сараас эхлэн үйлдвэрлээд байна. 2013 онд хийгдсэн өөрийн техник технологийг дахин шинэчлэх, шинэ Пивоны үйлдвэрийн ажлын хүрээнд, АPU company нь өөрийн пивоны үйлдвэрлэлд томоохон хөрөнгө оруулалтыг хийсний дагуу "Сэрүүн" брэндийн онцлог болох Сэрүүн шүүлтийн системийг ашиглаж эхэлсэн нь уг брэндийн сэтгэл сэргээм зөөлөн амтны нууц юм. Орчин үеийн дэлхийн чиг хандлага болон хэрэглэгчдийн хүлээлтэд нийцүүлэн хөгжүүлсэн уг брэнд нь савлагааны өргөн сонголттой бөгөөд зөөлөн шар айраг хэрэглэхийг эрхэмлэдэг хэн бүхний сонголт болж байна.

КАЛТЕНБЕРГ

Герман улсын Баварийн Хунтайжийн удам дамжсан нууц жорын дагуу үйлдвэрлэгддэг "Калтенберг" брэндийг АPU company нь 2013 онд анх зах зээлд гаргасан бөгөөд Монголдоо анх удаа үйлдвэрлэсэн Улаанбуудайн шар айраг гэдгээрээ онцлогтой. Бидний өнөөг хүртэл мэдэх лагер төрлийн шар айргийг арвайн соёолжоор исгэн үйлдвэрлэдэг байсан бол улаанбуудайн соёолжоор исгэн үйлдвэрлэсэн энэхүү шар айраг нь илүү зөөлөн, оргилсон амтыг мэдрүүлдэг. Зах зээлд гарсан цагаасаа эхлэн Монголын хэрэглэгчдэд сайтар танигдаад буй уг брэнд нь Германы шар айрагны түүхт цэвэр тунгалагийн хуулийн дагуу исгэгддэг.

АЛТАНГОВЬ

Өмнийн их говиор нэрлэгдсэн "Алтан Говь" брэндийг АPU company 2003 онд Монголын анхны дээд зэрэглэлийн шар айраг болгон үйлдвэрлэж эхэлсэн. Монголын зах зээлд импортын шар айраг ноёлсон, үндэсний үйлдвэрлэл сайнгүй байсан энэ үед, Монголынхоо хэрэглэгчдэд тээвэрлэлтийн хугацааг нэмэх гэж амт чанарт нь өөрчлөлт оруулаагүй, жинхэнэ шар айрагны цэвэр тунгалагийн хуулийн дагуу үйлдвэрлэсэн дээд зэрэглэлийн шар айргийг таниулахыг зорин энэхүү брэндийг үйлдвэрлэсэн. Гүн алтлаг, сонгодог пильснер төрлийн цэвэр сайхан амтыг мэдрүүлэх уг брэнд нь Монголын анхны дээд зэрэглэлийн шар айраг гэдгээрээ Монголынхоо хэрэглэгчдэд хэдийнээ танигдаад байна.

НИЙСЛЭЛ

Их хотын залуусын хэрэглээг илэрхийлсээр ирсэн "Нийслэл" брэнд нь 1972 оноос улбаатай. Анх "Нийслэлийн пиво" гэдэг нэрээр гардаг байсан уг брэнд нь 2010 онд дахин шинэчлэгдэн, өөрийн салшгүй түүхт Нийслэл хотын өнгө төрхийг агуулан хэрэглэгчдийн гар дээр хүрсэн. Орчин үеийн болон уламжлалт Герман технологийг ашиглан үйлдвэрлэдэг "Нийслэл" брэнд нь их хотын шинэхэн шар айрагны амтыг "Нийслэл"-чүүддээ болон Монголынхоо нийт ард түмэндээ хүргэж байна.

ХАР ХОРУМ

Монголын хамгийн анхны хар пиво "Хар Хорум" брэндийг 2003 онд анхлан үйлдвэрлэсэн бөгөөд Монгол түмний эртний түүхт нийслэл Хар Хорум хотын нэрийг брэндийн онцлог шинжтэй уялдуулан нэрлэсэн. Шинэхэн хар талхны үнэрийг шил болгоноосоо хэрэглэгчдэд мэдрүүлэх уг пиво нь дункел төрлөөр үйлдвэрлэгддэг бөгөөд сонгодог хар пивоны жинхэнэ төлөөлөл болсон брэнд юм.

HOPS & MALT

Монголын задгай шар айрагны түүх, хувьслыг бий болгосон "Hops & Malt" брэнд нь өнөөдөр задгай байдлаар АPU company-н томоохон харилцагчдаар борлуулагдан хэрэглэгчиддээ хүрч байна. Уг брэнд нь задгай шар айрагны стандарт, хэм хэмжээг дахин тодорхойлж, хэрэглэгчдэд шар айргийг шинээр нь хүргэдгээрээ онцлог.

АРХИНЫ БИЗНЕС

БРЭНД ХӨГЖҮҮЛЭЛТ БА ИННОВАЦИ

Дэлхийн стандартад нийцсэн тоног төхөөрөмж, технологийн хөгжлийг Монголд нутагшуулах хэрэглэгчдийн хүсэл, сонирхол, хэрэглээний онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн бий болгоход брэнд хөгжүүлэлт, инновацийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна. Бид хэрэглэгчийнхээ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн цагаан архины хатуулгын хэмжээг бууруулах, Монголын хөрсөнд ургасан олон төрлийн ашиг тустай ургамлууд болон үндсэн түүхий эд болох улаанбуудайг дотоодын газар тариалангийн аж ахуй эрхлэгчдээс 100% хүлээн авч хамтран ажилладаг.

Бид Болор, Архи, Улаанбаатар, Алтантүрүү брэндүүдээ хэрэглэгчдийн зан төлөв, хүсэл сонирхол, хэрэглээний хандлагад нийцүүлэн хөгжүүлж хэрэглэгчдэдээ хүргэсээр байгаа төдийгүй шинэ үеийн хэрэглэгчдийн өнөөгийн зан төлөв, олон төрлийн хэрэглээний хэв маягт нийцүүлэн хөгжүүлж бүтээгдэхүүнээ Их Британи, АНУ, ОХУ, БНХАУ тэргүүтэй 10 орчим улсад экспортолж байна.

Бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарын баталгааг улам бүр төгөлдөржүүлэх зорилгоор цагаан архины брэндүүдийн бөглөөг шинэ үеийн дэвшилтэт технологийн шийдэл болсон илэрхий нууцлал бүхий бөглөөгөөр солих хөрөнгө оруулалтыг 2015 онд хийлээ. Дээрх хөрөнгө оруулалтын үр дүнд дэлхийд бөглөө үйлдвэрлэлээр тэргүүлэгч Guala Closures group компанитай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж илэрхий нууцлал бүхий бөглөөг 3 жилийн турш онцгой эрхтэйгээр APU компануд нийлүүлэх гэрээг байгууллаа.

АРХИНЫ ЗАХ ЗЭЭЛ

Эдийн засаг, хэрэглэгчдийн хэрэглээний шилжилт зэргээс шалтгаалан дэлхий дахинд архины зах зээлийн өсөлт зогсонги байдалд шилжээд байна. Дэлхийн хэмжээнд 2015 онд 4,480 сая литр архи борлуулагдсан нь 2014 оноос 0.1% өссөн үзүүлэлт юм. Бүс нутгаар нь үзвэл Ази, Номхон далайн орнуудад архины зах зээл хамгийн өндөр хувиар буюу 3.6% өссөн, Хойд, Өмнөд Америк 1.5%, Африк болон Дундад Ази 0.8% өссөн бол Европ -0.7% буурсан байна. Европын архины зах зээлийн бууралтад Зүүн Европын бүс, тэр дундаа ОХУ дахь бууралт хүчтэй нөлөөлсөн байна.

Олон улс дахь нөхцөл байдал Монголын архины зах зээлд мөн нөлөөлж байна. 2015 оны гүйцэтгэлээр Монголын цагаан архины борлуулалт 2014 оны төвшнөөс даруй 9% буурлаа. Сүүлийн 3 жилд (2013-2015) жилд дунджаар 10.5% буурсан.



УС УНДАА ЖҮҮСНИЙ БИЗНЕС

УС УНДАА ЖҮҮСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн ундааны зах зээл жилд дунджаар 4,7%-р нэмэгдэж байгаа бөгөөд 2018 онд 706,9 тэрбум литрт хүрэх магадлалтай байна.

Дэлхийн хэмжээнд худалдаалагдаж байгаа ундааны 34,7%-ийг хийжүүлсэн ундаа эзэлдэг боловч сүүлийн жилүүдэд өсөлтийн хурдаар савласан ус, спортын болон функциональ ундаа, энергийн ундаа тэргүүлэх хандлагатай байна.

Эрс тэс уур амьсгалтай жилийн дөрвөн улиралтай, нэмэх хасах градусын хэлбэлзэл өндөртэй манай зах зээлд дулааны улирлын үргэлжлэх хугацаанаас ус, ундаа, жүүсний хэрэглээний өөрчлөлт шууд хамааралтай байдаг.



БРЭНД ХӨГЖҮҮЛЭЛТ БА ИННОВАЦИ

Бид ус ундааны зах зээлд Тэрэлж, Сэлэнгэ, Оргилуун, Фрутта, АРУ цэвэр ус нэрийн 17 төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ хүргэдэг. Бүтээгдэхүүн бүр маань эрүүл мэндэд ашиг тустай чанараараа хэрэглэгчдэд танигдсан шалтгаан нь үйлдвэрлэлдээ байгалийн гаралтай ургамал, жимс, жимсгэнэ ашигладагт оршдог.

ОРГИЛУУН

Оргилуун брэнд бол эх орны цэвэр тунгалаг усаар хүний өдөр тутмын хэрэглээнд зориулан бүтээгдэж, кальцийн ион, сульфат ион, хлорын ион, калийн ион, магнийн ион зэрэг нэгдлүүдийг агуулдаг тул хүний биеийн эрдсийн агууламжийг нөхөх үнэт чанартай бүтээгдэхүүн юм. Уг хийжүүлсэн ус нь хүний биеийн шингэнийг нөхөх чанараараа эрүүл мэндэд онцгой ач тустай.

ТЭРЭЛЖ

“Тэрэлж” хийжүүлсэн ундаа нь хоол боловсруулах эрхтэн, бөөрний үйл ажиллагааг сайжруулах үйлчилгээтэй бүтээгдэхүүн юм. Энэ бүтээгдэхүүнийг 1981 оноос эхэлж үйлдвэрлэсэн.

СЭЛЭНГЭ

Амьсгалын зам болон цусны эргэлтийг сайжруулах, бие махбодийг сэргээх үйлчилгээтэй “Сэлэнгэ” хийжүүлсэн ундаа нь нохойн хошуу, ганга өвс, чихэр өвс, шилмүүс зэрэг анхилуун үнэртэй, сэргээх үйлчилгээтэй, байгалийн гаралтай түүхий эдийг агуулсан бүтээгдэхүүн юм. Цэвэр байгалийн гаралтай, химийн найрлага ороогүй “Сэлэнгэ” брэндийг 1981 онд анх худалдаанд мөн гаргасан. Тэрэлж, Сэлэнгэ брэндийг үнэнч хэрэглэгчид маань өнөөг хүртэл таашаан хэрэглэсээр байна.

2015 ОНД ШИНЭЭР ГАРСАН БРЭНДҮҮД:

ШИНЭ БРЭНД:



ДЭЭЖ

Орчин үеийн дэвшилтэд технологийг цагаан идээ бэлтгэх уламжлалт аргатай хослуулан ур ухаан, сэтгэл зүрхээ шингээж үйлдвэрлэсэн Дээж нэрийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ хүргэлээ.
Савлагаа: 1 л
Төрөл: Сүү, тараг
Тослог: сүү 3.5%, тараг 1.5%



СЭРҮҮН

Жинхэнэ Light шар айраг Сэрүүн брэндийг шар айрагны дэвшилтэд технологи сэрүүн шүүлтийн системийг ашиглан, шинэ үеийн хэрэглэгчдийн хүсэл эрмэлзэлд нийцүүлэн үйлдвэрлэж, худалдаанд гаргалаа.
Хатуулаг: 4.8%
Савлагаа: 0.5 шил, 0.33, 0.45 лааз, 2.5 л пэт



ALPHA

Орчин үеийн чиг хандлагыг илэрхийлэх Альфа архийг үйлдвэрлэхдээ жирийн шүүлтүүрээс гадна мөнгөн болон алмазан шүүлтүүрийг нэмж өгснөөр бүтээгдэхүүний амтыг илүү зөөлрүүлж, уухад таатай болгосон.
Хатуулаг: 38%
Савлагаа: 0.75л, 0.5 л

ШИНЭЧЛЭГДСЭН БРЭНД:



ARKHI SILVER

ARKHI брэндийн шинэ нэр төрлийн зөөлөн архийг ARKHI silver болгон 0.5л, 0.75л-ийн савлагаатай 35%-ийн хатуулагтайгаар худалдаанд гаргасан.
Хатуулга: 35%
Савлагаа: 0.5л, 0.75л



АЛТАНГОВЬ

Өрнийн их говиор нэрлэгдсэн Алтанговь брэнд нь Монголын хамгийн анхны пильснер төрлийн дээд зэрэглэлийн шар айраг юм. Энэхүү шар айрагны шошго, сав баглаа боодлыг шинэчлэн худалдаанд гаргасан.
Хатуулага: 5.1%
Савлагаа: 0.45 шил, 0.45 лааз

2015 ОНД ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД:

НЭР ТӨРӨЛ НЭМЭГДСЭН БРЭНД:



БОЛОР ICE, БОЛОР MINT

Брэндийн нэр төрлийг нэмэгдүүлэн зөөлөн амт Болор ICE болон гааны сэнгэсэн амттай Болор Mint архийг орчин үеийн шинэ, өвөрмөц шийдэл бүхий савлагаатайгаар худалдаанд гаргалаа. Мөн Болор брэнд 1 л савлагаатайгаар хэрэглэгчиддээ хүрч байна.
Хатуулаг: 39.5%
Савлагаа: 1л, 0.75л



ОРГИЛУУН

Монголын анхны хийжүүлсэн ус Оргилуун нэр төрлөө нэмэн, шинэлэг сэргэг мэдрэмжийг төрүүлэх 5 төрлийн амттайгаар хэрэглэгчиддээ хүрлээ.
Савлагаа: 0.33 лааз, 0.5 пет
Төрөл: Сонгодог, Нимбэг, Ойн жимс, Грейпфрут, Тарвас



САЙН АЯГАТАЙ ЙОГУРТ

Сайн жимстэй йогуртууд нь хүний биед шаардлагатай олон төрлийн амин дэм, эрдэс бодисуудын цуглуулга 6 төрлийн жимсний амттай, аяган савлагаатайгаар худалдаанд гарлаа.
Савлагаа: 150гр
Төрөл: Гүзээлзгэнэ, Тоор, Ойн жимст, Олон жимст, Интоор, Хад



ЗӨӨХИЙ

А, С, Е, РР, В2, В12 витаминуудаар баялаг Сайн зөөхий нь 150гр, 350гр-аар аяган савлагаатайгаар 20% тослогтойгоор худалдаанд гарлаа.
Савлагаа: 150гр, 350гр
Тослог: 20%

ISO 22000
ISO 14001



APU company нь ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон ISO 22000, FSSC 22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны баталгаажуулалтын стандартуудыг хамтад нь нэвтрүүлсэн Монголын анхны компани юм.

Монгол Улсын Хүнсний тухай хууль тогтоомжид ХҮНС гэж хүний бие махбодийн өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах шим тэжээл бүхий хүнсний түүхий эд, бэлдэц, хоол, идээ, ундаа, ундны усыг хэлнэ хэмээн заасан байдаг. Хүнс гэдэг нь хүний амьдралын хамгийн чухал анхдагч хэрэгцээ тул хүнсний бүхий л хэлхээнд хүнсний аюулгүй байдлыг өндөр хэмжээнд хангах нь үйлдвэрлэгч бидний хүлээсэн өндөр хариуцлага, хүндтэй үүрэг юм. Ашиг орлогоос илүүтэй бүтээгдэхүүний чанар аюулгүй найдвартай байдлаараа өрсөлдөх болсон өнөөгийн зах зээлийн өрсөлдөөнт нийгмийн тооны чанараас тогтолцооны найдвартай байдлыг илүүтэй үнэлэх болсон цаг үе. Хүнс үйлдвэрлэгчийн энэхүү харилцааг дэмжих гол хэрэгслүүр нь Олон улсын ISO 22000, ISO 14001 бүлэг стандартууд юм. APU company нь түүхий эд бэлтгэн нийлүүлэлтээс эхлэн хүнс үйлдвэрлэх, тээвэрлэх ба хадгалах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон хавсран гүйцэтгэгчдийг дамжин жижиглэн худалдаалах хүртэл байгальд ээлтэй үйлдвэрлэлийг эрхэмлэн, хүнсний аюулгүй байдлын тогтолцоо, үйл ажиллагаагаа олон улсын SGS байгууллагаар жил бүр итгэмжлэгдэн ажиллаж байна.

ЧАНАРЫН
УДИРДЛАГА

Бид бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд түүхий эд материалыг хүлээн авах, хадгалах, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л шатанд сорилт, шинжилгээ, туршилт, баталгаажуулалтанд хяналт тавьж ажилладаг. Манай итгэмжлэгдсэн лаборатори нь олон улсын стандартын байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журам, шинжилгээний арга аргачлал, норматив техникийн баримт бичгүүд болон ISO/IEC 17025 стандартыг мөрдлөг болгон үйлдвэрлэлд орж буй үндсэн болон туслах түүхий эд материал, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнд итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу мэдрэхүй эрхтний, микробиологийн, физик-химийн шинжилгээг үнэн зөв хийж, стандарт шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн гаргахад, технологийн дамжлага бүрт хяналт тавьдаг.

Манай компани үндсэн 3 лабораторитой бөгөөд лабораториуд нь Олон улсын Сорилтын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO-17025:2007 стандартыг хангасан олон улсад лабораторийн тоног төхөөрөмжөөр тэргүүлэгч АНУ, Герман, Австри, Солонгос, ОХУ-ын орчин үеийн шилдэг, нано технологи бүхий өндөр мэдрэмжит тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.

CERTIFIED COMPANY




БИД ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА
ЧАНАР, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДАРААХ
БОДЛОГЫГ БАРИМТЛАН АЖИЛЛАДАГ.

- ✓ Хууль эрхзүйн болон хэрэглэгчийн шаардлагад бүрэн нийцсэн, хүнсний аюулгүй байдлыг 100 хувь хангасан, дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- ✓ Хүнс үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд FSSC 22000:2010, ISO 9001:2008 стандартуудын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, байнгын сайжруулалтыг хангана.
- ✓ Хүний нөөцийн хөгжил, техник, технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, шингэн хүнс үйлдвэрлэлийн манлайлагч компани болно.
- ✓ Хүнсний аюулгүй байдал болон чанарын удирдлагын тогтолцоонд гадаад, дотоод аудитын шалгалт хийх замаар үр дүнг баталгаажуулж ажиллана.



ҮЙЛ АЖИЛЛАГАА



Судалгаа, шинжилгээ

Бид олон улсын дэвшилтэт технологи, ноу-хауг судлан Монгол ажилчид, инженерүүдийн ур ухаанаар дэлхийн чиг хандлага, инновацийг Монголын хөрснөө буулгаж, зах зээлийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн хөгжүүлэлтийг хийдэг.



Дотоод - 109
Гадаад - 37

НИЙЛҮҮЛЭГЧ


APU company-н үйл ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин тэлсээр зөвхөн Монгол улсаар хязгаарлагдахгүй олон улсыг хамарч байна. Бид үйл ажиллагааны жигд тасралтгүй байдлыг хангахын зэрэгцээ FSSC 22000: 2010, ISO 9001:2008 стандартуудыг нэвтрүүлсэн гадаад, дотоодын 140 гаруй нийлүүлэгчдээс түүхий эд материалаа хүлээн авч, хамтран ажилладаг. Бид шинэчлэл, бүтээгдэхүүний чанартай байдлыг ханган ажиллахыг зорихын зэрэгцээ бүтээгдэхүүний орц найрлага, сав баглаа боодлын хэрэглээг илүү байгаль орчинд ээлтэй байхаар сонгодог бөгөөд үүнтэй уялдсан худалдан авалтын бодлого журмуудыг баримталдаг.



Бүтээгдэхүүн - 116

ҮЙЛДВЭРЛЭЛ

Түүхий эд материал, үйлдвэрлэлийн процесс, бэлэн бүтээгдэхүүн хадгалалт, хүргэлт зэрэгт чанарын өндөр түвшний хяналт шалгалтыг хийж 116 нэр төрлийн дээд зэргийн чанартай бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэхийн төлөө шингэн хүнс бизнес группын 1827 ажилтан ажил үүргээ хариуцлагатайгаар биелүүлэн ажиллаж байна.



Монгол улсын
21 аймаг,
283 сумд
Экспорт – 8 улс

ТҮГЭЭЛТ

Бүтээгдэхүүн тус бүрийн онцлогт тохирсон хадгалалтын горим, орчин үеийн техник технологи, програм хангамжийг нэвтрүүлсэн 96,000 м3 багтаамжтай, 11 давхар ган хийц бүхий Ложистик бүрэн автомат агуулахаараа дамжуулан Америк, Канад, Сологос, Хонг-Конг зэрэг 8 улсад бүтээгдэхүүнээ экспортлохоос гадна Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болон 21 аймаг, 283 сумдуудад бүтээгдэхүүнээ түгээдэг



Борлуулагч 7000

БОРЛУУЛАЛТ

Бид хэрэглэгч, борлуулагчиддаа зөв зохистой хэрэглээг дэлгэрүүлэгч, сурталчлагч байхыг эрхэмлэдэг. Бүс нутгийнхаа болон олон улсын хууль тогтоомжуудыг мөрдөн бүтээгдэхүүнээ 7000 гаруй борлуулалтын сувгаар дамжуулан худалдаалдаг.



ХЭРЭГЛЭГЧ



ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ, ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД



ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

APU company бол хувьцаа нь нийтэд нээлттэй арилжаалагддаг хувьцаат компани бөгөөд Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй, ТОП-20 индексийг бүрдүүлэгч компани юм.

Компанийн удирдлагын бүтэц нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагаас бүрдэх ба Гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал гүйцэтгэнэ. Төлөөлөн удирдах зөвлөл нь АPU company-н удирдлагын дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн хурлыг төлөөлж Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянан удирдаж, үйл ажиллагаагаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнадаг.

APU company нь Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоос гадна Компанийн засаглалын кодекс (2014 оны 5 сард шинэчлэн батлагдсан хувилбар)-г даган мөрдөх үүрэг хүлээсэн бөгөөд хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

КОМПАНИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

APU company-н ёс зүйн зарчим нь компанийн ёс зүй, удирдлагын ёс зүй, үйлдвэрлэгчийн ёс зүйн зарчмаас бүрдсэн бөгөөд Нийгмийн хариуцлагын бодлого, Удирдлагын ёс зүйн дүрэм, Байгаль орчны бодлого, Хүнсний аюулгүй байдлын бодлого, Хөдөлмөрийн дотоод журам зэрэг холбогдох бодлогын баримт бичгүүдээр тодорхойлогдсон. Үүнд төрийн хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага төдийгүй, олон улсын шилдэг туршлагуудыг тусгахад анхааран ажилладаг.

APU company-н ёс зүйн зарчим нь дараах үндсэн асуудлуудыг сууриа болгон тодорхойлсон, үүнд:

1. **Төрийн хууль тогтоомж, дүрэм журамтай уялдаатай байдал:** Хуульд захирагдах нь АPU company-н ёс зүйн зарчмын үндэс болно.
2. **Ашиг, сонирхлын зөрчил:** Удирдлага, ажилтны ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, ил тод мэдээлэх, компанийн үйл ажиллагаа зохих ёсоор, үр ашигтай явагдахад саад болохгүй байх явдлыг хангах зарчмыг баримтална.
3. **Нууцлал:** Мэдээллийн нууцлалыг хуульд нийцсэн зохистой түвшинд зохицуулан ажиллана.
4. **Өрсөлдөөн ба шударга байдал:** Бизнесийн өрсөлдөөн үнэн шударга, эрх тэгш байхыг эрмэлзэнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

APU company-н Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) 9 гишүүнээс бүрдсэн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг төлөөлж компанийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хянах үүрэгтэй. Өөрийн чиг үүргийг гүйцэтгэхдээ, ТУЗ нь Компани, түүнтэй харилцан хамааралтай этгээд болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг удирдамжаа болгодог.

ТУЗ нь АPU company-н бизнесийн стратегийг тодорхойлох, хэрэгжилтийг нь хангуулах, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо үр дүнтэй ажиллах, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцоо хуульд нийцсэн байх, Компанийн үйл ажиллагаа нь нийгмийн хариуцлагын зарчмыг даган мөрдөх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдсан байх зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

ТУЗ нь АPU company-н бизнесийн стратеги болон тулгарч буй эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцооны үйл ажиллагааг жилд хамгийн цөөндөө нэг удаа хянан хэлэлцэж, шаардлагатай шийдвэрүүдийг гарган ажилладаг.

ТУЗ доторх чиг үүргийн хуваарилалтыг ТУЗ-ийн үйл ажиллагааны холбогдох дүрэм журмаар тодорхойлсон бөгөөд эдгээр баримтыг Компанийн цахим хуудсанд байршуулсан.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улиран томилох, хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгох зэрэг шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргана. ТУЗ-ийг 3 жилээр томилох бөгөөд улиран сонгогдох боломжтой.

ТУЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцдаг бөгөөд ТУЗ-ийн ажлын албын үйл ажиллагааг удирдан ажиллана. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь компанийн засаглалтай холбоотой асуудлыг шууд хариуцах эрх бүхий албан тушаалтан мөн.

ТУЗ-ИЙН ТАНИЛЦУУЛГА, БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ нь 9 ГИШҮҮНТЭЙ, ҮҮНЭЭС 3 НЬ ХАРААТ БУС ГИШҮҮН

Пүрэвийн Батсайхан (ТУЗ-ийн дарга)
Пүрэвийн Батчимэг
Бүрэнтогтохын Батбаяр
Сергей Громов

Хьюго Барретт
Харон Хамхоев
Александр Сиваев (Хараат бус гишүүн)
Үнэнбат (Хараат бус гишүүн)
Сосорбарамын Эрдэнэ (Хараат бус гишүүн)

ГИШҮҮДИЙН МЭРГЭЖИЛ, АЖЛЫН ТУРШЛАГА:



П.Батсайхан

Инженер мэргэжилтэй.
1993-1996 онд Шунхлай ХХК-ийн Ерөнхий захирал
1997-2008 онд Шунхлай групп ХХК-ийн Ерөнхий захирал
2002 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн дарга
2004-2008 онд АРУ company-н Гүйцэтгэх захирал
2008 оноос одоог хүртэл Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч
2010 оноос одоог хүртэл Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн дарга



П.Батчимэг

Багш мэргэжилтэй.
Орос хэлний багшийн дээд сургууль, Цагдаагийн академид багш, ахлах багш, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд мэргэжилтэн.
2004-2007 онд АПУ импекс ХХК-ийн Ерөнхий захирал
2005 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн гишүүн
2007 оноос одоог хүртэл АПУ Трейдинг ХХК-ийн Ерөнхий захирал
2008 оноос Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч



Б.Батбаяр

Эдийн засагч мэргэжилтэй.
1994-1996 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш
1999-2001 онд Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн Арилжааны банкны зөвлөх
2002-2012 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банкинд Ахлах мэргэжилтэн
2012 оноос одоог хүртэл Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
2013 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн гишүүн



Ж.Үнэнбат

Эдийн засагч мэргэжилтэй.
1990-2000 онд Монгол банкинд эдийн засагч, хэлтсийн дарга, Ерөнхийлөгч
1996-2000 онд Азийн хөгжлийн банк, Монгол улсыг хариуцсан захирал
2000-2006 онд Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал
2009-2015 онд Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал
2015 оноос одоог хүртэл Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал, Ерөнхий нарийн бичгийн дарга



С.Громов

Инженер мэргэжилтэй.
1992-1994 онд ОХУ-ын "Разноимпорт" ХХК-д менежер
1994-2000 онд "Транс-ворлд Аллюминум" компанийн Лондон дахь салбарын захирал
2001 оноос одоог хүртэл Чингисхаан банкны ТУЗ-ийн дарга
2013 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн гишүүн



Х.Барретт

Эдийн засагч мэргэжилтэй.
1990-1992 онд Блю Доор Девелопментс ХХК-д менежер
1992-1995 онд Транс-ворлд металз ХХК-д менежер
1995 оноос одоог хүртэл Орион Ресурс ХХК-ийн захирал
2013 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн гишүүн



Х.Хамхоев

Инженер-эдийн засагч мэргэжилтэй.
1990-1992 онд "Лион" ХХН-ийн орлогч захирал
1992-1994 онд "БрАЗ" үйлдвэрийн Казахстан дахь төлөөлөгчийн газрын орлогч захирал
1994-2000 онд "БрАЗ" үйлдвэрийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын орлогч захирал
2000 оноос одоог хүртэл "Орион Интернэшнл" ХХК-ийн Ерөнхий захирал
2015 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн гишүүн



А.Сиваев

Эрх зүйч-эдийн засагч мэргэжилтэй.
2001-2005 онд "Русский алюминий" компанийн охин компаниудад хэлтсийн дарга, санхүү хариуцсан захирал
2005 оноос одоог хүртэл "Красный яр" ХК-ийн санхүү хариуцсан захирал, Ерөнхий захирал
2015 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн гишүүн



С.Эрдэнэ

Хуульч мэргэжилтэй.
1990-1993 онд Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газарт Төлөөлөгч
1993-2000 онд Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст Төлөөлөгч, Тасгийн дарга
2000 оноос одоог хүртэл ЭДКС ХХК-ийн захирал, ТУЗ-ийн дарга
2013 оноос одоог хүртэл Нарта ХХК-ийн ТУЗ-ийн дарга
2014 оноос одоог хүртэл Нарта констракшн ХХК-ийн ТУЗ-ийн дарга
2015 оноос одоог хүртэл АРУ company-н ТУЗ-ийн гишүүн

ХОРООД

ТУЗ нь дэргэдээ Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороотой. Хороодын бүрэлдэхүүнийг дэлгэрэнгүй дурьдвал:

1. **Аудитын хороо:** Ж.Үнэнбат (хорооны дарга), Б.Батбаяр, С.Эрдэнэ.
Хорооны чиг үүрэг: Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх явдлыг хангуулах, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагнал, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.
2. **Цалин урамшууллын хороо:** С.Громов (хорооны дарга), С.Эрдэнэ, Ж.Үнэнбат.
Хорооны чиг үүрэг: Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж хянах, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах үндсэн чиг үүрэгтэй.
3. **Нэр дэвшүүлэх хороо:** П.Батсайхан (хорооны дарга), С.Эрдэнэ, А.Сиваев.
Хорооны чиг үүрэг: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох ажлыг зохион байгуулах, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үндсэн чиг үүрэгтэй.

ТУЗ-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог бөгөөд үйл ажиллагааны гүйцэтгэлтэй уялдсан урамшууллын тогтолцоо байхгүй.

ШИЙДВЭР ГАРГАХ ПРОЦЕСС

APU company-н ТУЗ-ийн ээлжит хурал улирал бүр хуралдах ба шаардлагатай бол ээлжит бус хурал болон эчнээ санал хураалтаар шийдвэр гаргана. Шийдвэрийг хуралд оролцсон гишүүд, эчнээ хураасан саналын дийлэнх олонхиор гаргана. Мөн түүнчлэн, Монгол Улсын Компанийн тухай хуульд зааснаар, их хэмжээний хэлцлийн тухайд зөвхөн санал нэгтгэйгээр шийдвэр гаргах (санал зөрсөн тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх), ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухайд ийм сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн саналаа түдгэлзүүлэх зэрэг зарчмуудыг баримтлан ажиллана.

Хурлаар шийдвэрлэх асуудалд санал оруулах, танилцуулах, шийдвэр гаргуулах процессыг ТУЗ-ийн үйл ажиллагааны дүрмээр нарийвчлан тодорхойлсон.

2015 онд ТУЗ-аас их хэмжээний хэлцэлтэй холбоотой шийдвэр гараагүй. Ашиг сонирхлын зөрчилтэй этгээд, харилцан хамааралтай этгээдийн жагсаалтыг жил бүр шинэчилж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг байгууллагад тайлагнадаг.

2015 оны байдлаар дараах харилцан хамааралтай этгээдийг тодорхойлсон:

1. АПУ Трейдинг ХХК
2. Депод ХХК
3. Шунхлай Трейдинг ХХК
4. Шунхлай ХХК
5. Хьюндай Моторс Монгол ХХК
6. Медиа Групп ХХК
7. Амилан. Е ХХК
8. НТВ Бродкастинг ХХК
9. Жи Эс Би Майнинг ХХК
10. Пауэр Юнит ХХК
11. Сантранс Монгол ХХК
12. Сантранс ХХК
13. Интернэшнл Медикал Сэнтер ХХК
14. Капитал Групп ХХК
15. Улаанбаатар Спирт ХХК
16. Жи Эс Би Капитал ХХК
17. Скайтел ХХК
18. Натур Агро ХХК
19. Ван Трейд ХХК
20. Грийт Эмпайр ХХК
21. Скаймедиа Корпораци ХХК
22. Монгол Даатгал ХХК
23. Чингис Хаан Банк ХХК
24. Блю Скай Кашемир ХХК
25. Гранд ХХК

ЦАЛИН УРАМШУУЛАЛ

APU company нь өөрийн цалин урамшууллын тогтолцоонд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг татан ажиллуулж, тогтвор суурьшилтай ажиллахад нь анхаарах;
- Ажилтан, ажиллагсдын карьерийн зохистой удирдлагыг хангах зорилгоор албан тушаал дэвшүүлэх, тасралтгүй суралцах нөхцөл боломж бүрдүүлэх, гадаад дотоодын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх, сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох;
- Ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг бодитойгоор үнэлэн, гүйцэтгэлд тохирсон урамшуулал олгох;
- Ажилтнуудын нийгмийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор нийгмийн хөгжлийн сан бүрдүүлж, тэтгэмж, дэмжлэг олгох;
- Жил бүр цалин хөлсний судалгаа хийж, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, макро эдийн засгийн төлөв, инфляцийн түвшинтэй уялдуулан цалин хөлсний түвшингээ нэмэгдүүлэх;
- APU company-н ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох; ажлыг зохион байгуулахыг холбогдох журмын дагуу Нэр дэвшүүлэх хороо хариуцан ажилладаг.


ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

1992 онд Архи пиво комбинатаас Архи, пиво, ундаа буюу АПУ Хувьцаат компани болон 49 хувийг хувьчилж, 2001 онд үлдсэн 51 хувийг дуудлага худалдаанд оруулан өмчлөх эрхийг шилжүүлсэнээр 100 хувь хувьчлагдсан түүхтэй.

APU company-н нь архи, пиво, ундаа, ус, жүүс үйлдвэрлэх, гадаад худалдаа, хүнс барааны бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, зоогийн газар баарны үйл ажиллагаа явуулахаар 2005

онд Улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн авсан бөгөөд хууль эрх зүйн орчин шинэчлэгдэн сайжирснаар нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр Улсын бүртгэлд бүртгэгдсэн.

APU company /Симбол APU/ нь 2015 оны байдлаар 4000 гаран хувьцаа эзэмшигчидтэй 74,287,700 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд Монголын хөрөнгийн биржээр чөлөөтэй арилжигддаг, TOP-20 компанийн нэг юм.



АРИЛЖААНЫ МЭДЭЭ		APU company	Нийт арилжаан дахь эрэмбэ
Арилжаалагдсан ширхэг	ширхэг	266,301	11
Үнийн дүн	Мян.төг	952,920	4

Монголын хөрөнгийн биржийн топ 20 индекс ба APU company-н хувьцааны ханш

APU company нь Монголын хөрөнгийн биржид арилжаа хийдэг дотоодын компаниудын нийт зах зээлийн үнэлгээний 19%-ийг эзэлдэг байсан бол 2015 оны эцэст 23%-ийг эзлэж байна.

ХЭРХЭН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ВЭ?

Та үнэт цаасны арилжаанд оролцохын тулд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр үйлчлүүлэх шаардлагатай тул зайлшгүй брокер, диллерийн компаниар дамжих шаардлагатай. Энэ нь аливаа эрсдлийг бууруулахад зориулагдсан байдаг ба хувьцаа худалдаж авахад үнэт цаасны ханшийн талаарх мэдээллийг авах, хувьцааг нь худалдаж авах гэж байгаа компанийнхаа үйл ажиллагааг судлах, санхүүгийн тайланг үзэх, ногдол ашиг тарааж байсан эсэхийг шалгах, удирдлагын менежментийг тандах, тухайн салбартаа эзлэх зах зээлийн байр суурийг нь харилцагч брокер диллерийн компаниасаа зөвлөгөө авах боломжтой юм.

Хэрэв та өмнө нь аливаа нэг байгууллагын хувьцааг эзэмшиж байгаагүй, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд дансгүй бол үйл ажиллагаа явуулах

тусгай зөвшөөрөл авсан, Хөрөнгийн биржэд арилжаа хийдэг брокер дилерийн компаниудаас нэгийг сонгон, иргэний үнэмлэхтэйгээ очин данс нээлгэнэ.

Манай улсад одоогийн байдлаар 40 гаруй брокер диллерийн компани бий. Тэдний орших хаяг, холбогдох утасны дугаарыг ҮЦТТТХТ-д очиж мэдэхээс гадна WWW.MSE.MN гэсэн вебсайтаас авч болно.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд данстай болсны дараа дансандаа мөнгө байршуулснаар та брокер дилерийн компаниар дамжуулан үнэт цаасны арилжаанд орох эрхтэй болно. Ингээд брокер дилерийн компанидаа төлөх шимэтгэлээ байршуулаад тус компанитайгаа худалдах, худалдан авах захиалгын гэрээ үйлдэн захиалгаа өгнө.

НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

APU company нь 2005 онд хувьчлагдсанаас хойш ногдол ашгийн бодлогыг хэрэгжүүлж хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой түвшинд байлгах бодлого баримтлан ажиллаж байна. Ногдол ашгийг хуваарилах шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг юм.

APU company-н хувьд 2005 оноос одоог хүртэл ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ тасралтгүй зарлаж ирсэн бөгөөд "Нэгж хувьцаанд тогтмол ногдуулах" ногдол ашгийн бодлого барьж ирсэн.

	Ногдол ашиг тараасан хувьцаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Нийт ногдол ашиг /сая.төг/	Нэгж хувьцаанд ногдох дивиденд/%/
2005 он	742,877	130	97	
2006 он	742,877	60	45	
2007 он	742,877	538	400	2.80%
2008 он	74,287,700	10	743	2.30%
2009 он	74,167,019	20	1,483	3.20%
2010 он	74,167,019	40	2,967	2.00%
2011 он	74,167,019	60	4,450	1.40%
2012 он	74,167,019	70	5,192	1.80%
2013 он	74,167,019	90	6,675	2.20%
2014 он	74,167,019	0	-	
2015 он	74,167,019	70	5,192	1.80%

Өнгөрсөн хугацаанд APU company-н олгож байсан ногдол ашгийн хэмжээг харвал олон улсын шингэн хүнсний компаниудын дундаж үзүүлэлт болох 2,6%-тай ижил хэмжээнд байна.

	Dividend Yield %
Beverage industry /brewing/ average	2.64
HEINEKEN (HEIA.AS)	1.68

Эх сурвалж: finance.yahoo.com

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Гүйцэтгэх захирлын дэргэд, түүнийг шийдвэр гаргахад зөвлөх, туслах чиг үүрэг бүхий 6 гишүүнтэй Захирлын зөвлөл ажилладаг. Захирлын зөвлөлийг Гүйцэтгэх захирал даргалах бөгөөд Үйлдвэрлэл үйл ажиллагаа хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Захиргаа хүний нөөц хариуцсан захирал, Төсөл хариуцсан захирал, Харилцаа инноваци хариуцсан захирал гэсэн 6 гишүүний бүрэлдэхүүнтэй.



ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа хариуцсан захирал



БАНЗРАГЧИЙН ТҮВШИН
Санхүү хариуцсан захирал



АВИРМЭДИЙН МЭНДБАЯР
Төсөл хариуцсан захирал



АРИУНАА ДАНДАРОВА
Харилцаа, Инноваци хариуцсан захирал



МИЖИДИЙН БАТЦЭРЭН
Захиргаа, Хүний нөөц хариуцсан захирал

ШАГНАЛ

TOP-100 АЖ АХУЙ НЭГЖ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим,

ШИЛДЭГ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖТАЙ, ЦЭМЦГЭР БАЙГУУЛЛАГА

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар

ХЭРЭГЛЭГЧДЭД ЭЭЛТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧ ARU СҮҮНИЙ ҮЙЛДВЭР

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар

ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ САВ БАГЛАА БООДОЛТОЙ БҮТЭЭГДЭХҮҮН САЙН БРЭНД

Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам

ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИТОЙ БҮТЭЭГДЭХҮҮН САЙН БРЭНД

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

WORLD VODKA AWARDS-2016

ARKHI, Соёмбо, Улаанбаатар

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Бид баялаг бүтээх замаар тогтвортой хөгжлийн үндсэн суурь зарчим болох ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ тэнцвэртэй хөгжлийг хангах үйл ажиллагаагаа үр ашигтай явуулахыг чиглэл болгосоор ирсэн.



ЭДИЙН ЗАСАГ

- Оролцогч талуудад үр ашгийн хүртээмжтэй байдлыг хүргэх
- Бүтээмжийг дээшлүүлэх замаар үр ашгийн нэмэгдүүлэх, баялаг бүтээх
- Үндэсний үйлдвэрлэгч
- Зардлыг бууруулах замаар үр ашгийг нэмэгдүүлэх



НИЙГЭМ

- Хүнсний аюулгүй байдал, түүний чанар, стандартыг дээд зэргээр ханган ажиллах
- Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хүний хөгжил, байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих үйлсэд хувь нэмрээ оруулах
- Шударга, ил тод өрсөлдөөний зарчимд тулгуурлан ажиллах
- Зохистой хэрэглээг нэвтрүүлэх
- Хэрэглээний боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах
- Хууль эрх зүй, ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн ажиллах
- Үл ялгаварлал, шударга байдлыг эрхэмлэх



БАЙГАЛЬ ОРЧИН

- Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах
- Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах
- Байгаль орчны талаарх хууль тогтоомж, стандартуудыг мөрдөх

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

“Эрчим хүчний хэмнэлт болон хог хаягдлыг бууруулах” хөтөлбөрийн хүрээнд, 2015 онд эрчим хүчний хэрэглээг 500,000 кВт-р бууруулсан.

УСНЫ ХЭМНЭЛТ

Үйлдвэрийн хэмжээнд саарал ус ашиглах дэд бүтцийг угсралт суурилуулалт хийж 6000 м³ усыг сэргээн ашиглаж 53 мянган м³ усыг 2015 онд хэмнэсэн.

УУР, ДУЛААНЫ ХӨРГӨЛТ

Үйлдвэрийн хөргөлтийн системээс дулааны энерги гаргах технологи нэвтрүүлж үйлдвэрийн халаалтын системд сэргээсэн дулаан ашиглаж байна.

Нүүрс хүчлийн хийг галын хор болгон ашиглаж шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдүүлсэн.

ХҮНИЙ НӨӨЦ ХӨГЖИЛ



2015 ОНД ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД БИД

Хувь хүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн 700 орчим мэргэжлийн болон ажлын байрны сургалтуудыг 2015 онд зохион байгууллаа.

Үүнд:

- Топ менежерүүдээ - Дэлхийн боловсролыг монголдоо буюу Харвард бизнес сургуулиас зохион байгуулсан Бизнесээ хэрхэн удирдах вэ сургалтанд хамруулсан.
- Инженер техникийн ажилчдаа - Залуу манлайлагч хөтөлбөр, Ажлын байран дахь мэргэжлийн 612 сургалтанд хамруулаад байна.
- Мөн ажилтан бүрийн хувь хүний хөгжил, манлайллыг хөгжүүлэх замаар сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, компанийн үнэ цэнийг өсгөх зорилготойгоор "Төгөлдөр" төслийг санаачлан хэрэгжүүлсэн.

ТӨГӨЛДӨР ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИД

Хувь хүний хөгжил рүү чиглэсэн сонирхлын 9 бүлэг байгуулж, үүний үр дүнд хамт олны эв нэгдэл, дулаан уур амьсгал, үйлдвэр алба нэгжийн хоорондын уялдаа холбоо илүү сайжирч ажилчид маань чөлөөт цагаа хамтдаа зөв өнгөрүүлэх, эрүүл мэнд, ажил амьдралын зөв хэв маягийг амьдралдаа бий болгож харилцан суралцаж, туршлага солилцох боломжийг бүрдүүлэхэд компанийн зүгээс дэмжин ажиллалаа.

Ажилчдын дунд бий болсон сонирхлын 9 клубыг нэрлэвэл:

- APU cooking club
- APU music club
- APU Xtreme club
- APU hiking club
- APU dancing club
- APU photoshooting club
- APU creative plus club
- APU tennis club
- APU productivity club

Мөн төслийн хүрээнд бид Тунгалаг туул аян, Монгол цуур төсөл, Summer camp 2015, Эх-орон-36 хөтөлбөрүүдийг амжилттай зохион байгууллаа.

Дээрх ажлын үр дүнг ажилчдаас авсан соёлын судалгаанаас харахад 2015 онд сэтгэл ханамжийн индекс нь 2014 оныхоос харьцангуй өссөн буюу ESI = 7 , манлайллын индекс нь 5,9 гэсэн үзүүлэлттэй гарсан.

Мөн бид Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан гэрээгээ 100% биелүүлж, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1 тэрбум төгрөгийг зарцууллаа.

- Тэтгэвэр, тэтгэмж 110 сая төгрөг
- Дэмжлэг тусалцаа 125 сая төгрөг
- Шагнал, урамшуулал 25 сая төгрөг
- Өдрийн хоол, эрүүл мэндийн үйлчилгээнд 729 сая төгрөгийн тусламж үзүүлсэн.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХҮРЭЭНД ХИЙГДДЭГ АЖЛУУД:

- Ажилтнуудыг ая тухтай ажил амралтыг зохицуулан хоолны газрыг тохижуулан илчлэг сайтай хоолоор үнэгүй тогтмол үйлчилж байна
- Онцгой нөхцөлд ажилладаг ажилтнуудад өдөр бүр сүү тараг олгодог.
- Зөвхөн ажилчиддаа үйлчилдэг APU эмнэлэгтэй бөгөөд эмнэлэг нь яаралтай болон анхан шатны тусламжийг үзүүлэх, ажлын байрнаас хөндийрүүлэлгүй эмчлэн эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон амьдралын зөв дадал хэв маяг олгохтой холбоотой нийгэм эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг. Эмнэлэгийн үйлчилгээг өдөрт 20-25 хүн тогтмол авдаг бөгөөд 2015 онд 2014 оныхтой харьцуулахад ажилчдын өвчлөл 4%-иар буурсан үзүүлэлтэй байна.



2015 ОНД БИД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫНХАА ХҮРЭЭНД...



КОМПАНИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

APU company “Үр ашигтай эрсдэлийн удирдлага”-ыг ирээдүйд учирч болзошгүй тодорхой бус байдлыг бууруулахаас гадна олон төрлийн шинэ боломжуудыг олж нээх бололцоо олгодог, компанийн стратеги, үйл ажиллагааны зорилгодоо хүрэхэд зайлшгүй шаардлагатай бизнесийн салшгүй хэсэг гэж үздэг.

I. ҮНДСЭН ЭРСДЭЛҮҮД

Бид дараах байдлаар эрсдэлийг ангилан авч үздэг.

ЭРСДЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
<p>Улс төр, эдийн засгийн орчин муудах Улс төр, эдийн засгийн орчин муудах, түүний тодорхойгүй байдал нь бизнест хүчтэй нөлөөлдөг.</p> <p><i>Онцлох эрсдэлүүд:</i></p> <ul style="list-style-type: none"> Улс төрийн тогтворгүй байдал нэмэгдэх Валютын хэлбэлзлээс үүсэх зардал нэмэгдэх 	<ul style="list-style-type: none"> Улс төрийн байдал цаашдын хандлагыг ажиглах Валютын хөдөлгөөнийг судлах, таамаглах
<p>Хууль эрх зүй, зохицуулалтын өөрчлөлт Шингэн хүнс, түүн дотор согтууруулах ундааны үйлдвэрлэл маш их хараа хяналт дор байдаг.</p> <p><i>Онцлох эрсдэлүүд:</i></p> <ul style="list-style-type: none"> Худалдааны эрх чөлөө, үйл ажиллагаа хязгаарлагдах Татвар болон үүрэг хариуцлага нэмэгдэх 	<ul style="list-style-type: none"> Зохистой хэрэглээг дэмжин ажиллах Хуулийг дагаж мөрдүүлэх, хяналт тавих
<p>Нийгмийн орчин өөрчлөгдөх Глобалчлал, соёлын өөрчлөлтүүд нь хэрэглэгчийн сонголтод нөлөөлөх замаар зах зээлд хүчтэй нөлөөтэй</p> <p><i>Онцлох эрсдэлүүд:</i></p> <ul style="list-style-type: none"> Хэрэглэгчдийн сонирхол, сонголт өөрчлөгдөх Зах зээл буурах 	<ul style="list-style-type: none"> Нийгмийн өөрчлөлт шинэчлэлд бэлэн байх, урьдаас тооцоолох
<p>Байгалийн давагдашгүй хүч Байгалийн гамшигт, гэнэтийн үзэгдэл, цаг уурын цочир өөрчлөлт зэрэгт бид үргэлж хүчин мөхөс байсаар ирсэн.</p> <p><i>Онцлох эрсдэлүүд:</i></p> <ul style="list-style-type: none"> Газар хөдлөлт, хуй салхи, үер ус, гал түймэр Газар тариалан зогсох, зам харгуй эвдэрч сүйрэх, харилцаа холбоо тасрах 	<ul style="list-style-type: none"> Гамшгийн сургалт явуулах Яаралтай үед авах арга хэмжээг боловсруулах
<p>Технологийн өөрчлөлт Шинэ техник технологи бий болох судалгаа хөгжүүлэлт сайжирснаар өрсөлдөөн нэмэгддэг</p> <p><i>Онцлох эрсдэлүүд:</i></p> <p>Зах зээлд шинээр нэвтрэгсэд олширох Хэрэглэгчдийн шаардлага нэмэгддэг</p>	<ul style="list-style-type: none"> Өндөр технологийн орчинд хурдацтай дасан зохицох Судалгаа хөгжүүлэлтээ тасралтгүй сайжруулах

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

ЭРСДЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
<p>Эрүүл, аюулгүй орчин Онцлох эрсдэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Аваар осол тохиолдох, хүний амь нас эрсдэх Нийтийг хамарсан өвчин гарах 	<ul style="list-style-type: none"> АПУ Компани ажилчидаа байнгын сургалт, үзлэгт хамруулж, сонирхогчдын клубуудыг дэмжин, тав тухтай орчинд үдийн хоолоор үйлчлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэн ажилладаг.
<p>Бүтээгдэхүүний аюулгүй, бүрэн бүтэн байдал Онцлох эрсдэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Чанаргүй бүтээгдэхүүн хэрэглэгчид хүрэх Хэрэглэгчдийн эрүүл мэндэд аюул учрах 	<ul style="list-style-type: none"> АПУ Компани чанарын стандарт ISO 9001, хүнсний аюулгүй байдлын стандарт ISO 22000-уудыг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд түүхий эд материал ирхээс авхуулаад хэрэглэгчийн гарт бэлэн бүтээгдэхүүн хүрэх хүртэлх үе шат бүрт хяналт тавьж, чанар, стандартыг хангуулан ажилладаг.
<p>Мэдээллийн системийн аюулгүй байдал Онцлох эрсдэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Кибер халдлагад өртөх Их хэмжээний дата өгөгдөл буруу тархах 	<ul style="list-style-type: none"> Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг бэхжүүлэх Дата өгөгдлийг салангад болон нэгтгэх байршуулах замаар мэдээллийн аюулгүй, ачаалалгүй сувгийг нэвтрүүлэх
<p>Компанийн санхүүгийн орчин Онцлох эрсдэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Хөрвөх чадвар буурах Санхүүжилтийн эх үүсвэргүй болох 	<ul style="list-style-type: none"> Нөөцийг үр ашигтай, оновчтой хуваарилах Санхүүжилтын шинэ гарцуудыг олж илрүүлэх


КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛ

ЭРСДЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
<p>Комплайнс</p> <ul style="list-style-type: none"> Стандарт дүрэм, журмын шинэчлэл, ямар нэг хэм хэмжээг үл мөрдөх нь комплайнсын эрсдэлийг нэмэгдүүлж байдаг. <p>Онцлох эрсдэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> Хэм хэмжээг үл дагаж мөрдөх 	<ul style="list-style-type: none"> Комплайнсын талаарх сургалтыг бүх шатанд явуулж, ойлголт өгөх Үйл ажиллагаанд нэвтрүүлэх

Жич: Энэхүү хэсэгт боломжит бүх төрлийн эрсдэлүүдийг хамруулаагүй болно.

II. ЭРСДЭЛИЙН ТӨРХ

APU company эрсдэлийг үнэлэхдээ зөвхөн үүссэн эрсдэлийг үнэлэх биш түүний эх үүсвэр, учир шалтгааныг судалж, цаашид ямар үр дагавар гарч болох, компанийн аль түвшинд ямар зэрэглэлийн нөлөөлөл учруулахыг тооцсоноор эрсдэлийн цогц үнэлгээг хийхийг зорьдог. Ингэснээр тухайн эрсдэлд тохирох, оновчтой арга замуудыг сонгон хэрэгжүүлэх замаар эрсдэлийг бууруулж, удирдан ажилладаг.



ВАЛЮТЫН ЭРСДЭЛ

Тодорхойлолт: Монголын эдийн засаг өнгөрсөн жилүүдэд уул уурхайн салбарын хэмжээний гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой огцом өсч гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш чангарч байсан үе саяхан. Гэхдээ хөрөнгө оруулалт буурч, дэлхийн зах зээл дэх гол түүхий эдийн үнэ буурснаар уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай монголын эдийн засаг улам бүр хямарч 2013 оноос хойш ам доллар болон юанийн үнэ тасралтгүй өссөн.

Боломжит нөлөөлөл: Валютын тасралтгүй өсөлт нь компанийн түүхий эд материалын зардлыг нэмэгдүүлж, валютын хэлбэлзлээс үүсэх эрсдэлийн давтамж, нөлөөлөл нэмэгдсээр компанийн хувьд валютын эрсдэл нь өндөр зэрэглэлтэй эрсдэлийн түвшинд хүрээд байна.

Бууруулалт: Энэ тохиолдолд бид зайлсхийх болон бууруулах аргыг хослуулан ашигладаг ба валютын ханшны хэлбэлзэл, трендийг судалж, тогтмол мэдээлэх замаар валютын үнэ бага түвшинд байх үед урьдчилан нөөцөө нэмэгдүүлэх мөн зардлаа бууруулах замаар учирч болох нөлөөллийг тодорхой түвшинд барихыг зорин ажиллаж байна.

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭСРЭГ НИЙГМИЙН СӨРӨГ ДАЙРАЛТ

Тодорхойлолт: АPU company шингэн хүнсний зах зээлд үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулдаг ба согтууруулах ундаа үйлдвэрлэдэг учраас нийгмийн хариуцлагыг өндөр түвшинд ханган ажиллах үүрэг хүлээдэг.

Боломжит нөлөөлөл: Нийгэмд шингэн хүнс, тэр тусмаа согтууруулах ундааны хэрэгцээ шаардлага тасралтгүй оршоор байдаг хэдий ч ахиу хэрэглэснээр хүний бие, эрүүл мэндэд хор учруулж улмаар нийгмийн сөрөг сэтгэл зүйг нэмэгдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлд худалдааны хязгаар, татварын дарамт зэрэг олон арван шахалтууд бий болж компанийн үйл ажиллагаанд байнга нөлөөлж байдаг өндөр зэрэглэлийн эрсдэл юм.

Бууруулалт: АPU company-н хувьд үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар стандартыг өндөр түвшинд ханган ажилладаг ба хэрэглэгчиддээ дээд зэргийн чанартай, тунгалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх түүгээрээ дамжуулан согтууруулах ундааны зөв зохистой хэрэглээг нийгэмд нэвтрүүлэх замаар энэхүү эрсдэлийг удирдан ажиллахыг зорьдог.

СО₂-ЫН ХИЙ

Тодорхойлолт: Компанийн үйлдвэрлэл, ялангуяа буудайны чаналагын явцад нүүрс хүчлийн давхар исэл (СО₂)-ын хий жилд ойролцоогоор 590 тонн ялгардаг.

Боломжит нөлөөлөл: СО₂ нь хүний биед шууд сөрөг нөлөөгүй боловч агаар мандалд гарснаар удаан хугацаанд оршин тогтнох замаар дэлхийн дулаарлыг нэмэгдүүлэхэд буюу хүлэмжийн хийг ихэсгэхэд хүчтэй нөлөөлдөг тул дэлхий нийтээр СО₂ бууруулахад чиглэн ажилладаг учраас компанийн хувьд зайлшгүй удирдах шаардалагатай эрсдэл юм.

Бууруулалт: Манай компани ISO 14001 стандартыг хэрэгжүүлэгч байгаль орчиндоо ээлтэй үйлдвэрлэгчийн хувьд СО₂-ын хийг бууруулах, мөн тусгай хоолойнд хийг цэвэрлэж дахин үйлдвэрлэлд ашиглах боломжтой, хүнсний СО₂-ын хий болгосноор хийжүүлсэн ундаа үйлдвэрлэгч компаниудад түүхий эд материал болгон өгөх мөн СО₂-ын хийг галын хор болгон шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод хэрэгцээгээ хангах замаар тухайн эрсдэлийг бууруулахаар ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		2015	2014
ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	сая.төг	208,574.34	225,363.24
Биет бус хөрөнгө	сая.төг	645.07	883.42
Биологийн хөрөнгө	сая.төг	102.99	80.53
Урт хугацаат хөрөнгө оруулалт	сая.төг	904.84	904.84
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	8,449.75	5,538.93
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Бараа материал	сая.төг	218,667.0	232,770.95
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	сая.төг	56,009.83	73,714.19
Татвар, НДШ-ийн авлага	сая.төг	5,280.31	5,078.27
Дансны авлага	сая.төг	1,635.35	1,854.51
Дансны авлага	сая.төг	9,437.50	4,221.75
Бусад авлага	сая.төг	9,825.90	9,803.70
Бусад санхүүгийн хөрөнгө	сая.төг	33.81	33.81
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	6,762.57	9,946.98
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН НИЙТ ХӨРӨНГӨ			
	сая.төг	88,985.27	104,653.22
	сая.төг	307,662.26	337,424.17
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	сая.төг	74.17	74.17
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	80,694.98	80,494.96
Хуримтлагдсан ашиг	сая.төг	65,348.03	50,987.60
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ			
	сая.төг	146,117.18	131,556.73
ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат зээл	сая.төг	88,080.21	120,405.46
Хойшлогдсон татварын өр	сая.төг	648.90	476.04
Бусад өглөг	сая.төг	1,938.26	0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат зээл	сая.төг	90,667.37	120,881.50
Татварын өр	сая.төг	31,863.45	30,101.36
Бусад өглөг	сая.төг	11,564.55	12,495.04
	сая.төг	27,449.72	42,389.54
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР НИЙТ ӨР ТӨЛБӨР ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ			
	сая.төг	70,877.72	84,985.95
	сая.төг	161,545.09	205,867.44
	сая.төг	307,662.26	337,424.17

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		2015	2014
Борлуулалтын орлого	сая.төг	210,111.18	198,468.87
Борлуулалтын өртөг	сая.төг	146,597.51	154,521.13
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	сая.төг	63,513.67	43,947.75
Борлуулалт, удирдлагын зардал	сая.төг	26,709.54	29,78.41
Бусад орлого	сая.төг	1,301.19	739.34
Бусад зардал	сая.төг	(3,280.66)	(2,452.97)
Санхүүгийн орлого	сая.төг	91.51	135.70
Санхүүгийн зардал	сая.төг	6,758.81	5,334.33
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	сая.төг	(9,489.52)	(21,518.50)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	сая.төг	10.20	159.14.73
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	сая.төг	18,735.88	(14,251.67)
Орлогын татварын зардал	сая.төг	7,608.56	(77.64)
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	сая.төг	11,187.32	(14,174.03)
Хөрөнгийн үнэлгээний нэмэгдэл ба бусад	сая.төг	3,373.13	67,479.82
		-	-
ТАЙЛАНТ ҮЕИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	сая.төг	14,560.45	53,305.78

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		ХУВЬЦААТ КАПИТАЛ	ХАЛААСНЫ ХУВЬЦАА	ХУРИМТЛАГДСАН АШИГ	БУСАД НӨӨЦ	НИЙТ ДҮН
2013	сая.төг	74.29	(0.12)	70,502.62	14,349.19	84,925.98
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	1,334.05	66,145.77	67,479.82
Өмчид гаргасан өөрчлөлт	сая.төг	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	(6,675.03)	-	(6,675.03)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	(14,174.03)	-	(14,174.03)
2014	сая.төг	74.29	(0.12)	50,987.60	80,494.96	131,556.73
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	3,373.13	-	3,373.13
Өмчид гаргасан өөрчлөлт	сая.төг	-	-	(200.02)	200.02	-
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	11,187.32	-	11,187.32
2015	сая.төг	74.29	(0.12)	65,348.03	80,694.98	146,117.18

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		2015	2014
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ			
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	40,323.56	17,591.31
Бараа борлуулсны орлого	сая.төг	318,099.59	353,910.52
Бараа материал худалдан авахад төлсөн	сая.төг	(118,218.93)	(145,136.26)
Татвар, НД-ийн байгууллагуудад төлсөн	сая.төг	(121,085.37)	(144,436.70)
Ажиллагсадд төлсөн	сая.төг	(8,743.44)	(9,561.68)
Ашиглалтын зардалд төлсөн	сая.төг	(5,352.44)	(4,700.52)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэгт төлсөн	сая.төг	(4,320.42)	(4,546.97)
Хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(6,865.80)	(7,689.10)
Бусад мөнгөн орлого	сая.төг	1,688.36	2,989.77
Бусад мөнгөн зарлага	сая.төг	(14,877.99)	(23,237.75)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ			
АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	(4,486.44)	(19,189.55)
Мөнгөн орлого	сая.төг		251.50
Мөнгөн зарлага	сая.төг	(4,486.44)	(19,441.05)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ			
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	(39,021.53)	(17,290.03)
Мөнгөн орлого	сая.төг	209.04	10,292.48
Мөнгөн зарлага	сая.төг	(39,230.58)	(27,582.51)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	(3,184.41)	(18,888.27)
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	сая.төг	9,946.98	28,835.25
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	сая.төг	6,762.57	9,946.98

1. ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Тусдаа санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу, Монгол улсын хууль тогтоомж, түүний нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн. Тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт ("НББОУС") 27 буюу "Тусдаа Санхүүгийн Тайлан" хэмээх стандартын дагуу бэлтгэсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад өөрөөр тодруулсанаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн, бүх тайлант үе бүрт уг бодлогуудыг тууштай хэрэгжүүлсэн болно.

БҮРТГЭЛИЙН БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Тусдаа санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцоолоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА

Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ТҮРЭЭСИЙН ХӨРӨНГӨ

Түрээсийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, эзэмшил компанид бүрэн шилжсэн гэж үзсэн тохиолдолд санхүүгийн түрээсээр ангилж, бүртгэдэг. Санхүүгийн түрээсийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгийн бодит үнэ цэнэ болон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар бүртгэдэг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ

Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

ЭНГИЙН ХУВЬЦАА

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг. Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

БАРАА БОРЛУУЛАЛТ

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

БУСАД ОРЛОГО

Компаний үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулж, ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг түрээсийн хугацаанд нийт түрээсийн зардлын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

ТАЙЛБАР ТОЛЬ

ТАЙЛАНТ ҮЕ

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

ХӨРӨНГӨ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчиддээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүдвэл гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

ҮНДСЭН ХӨРӨНГИЙГ ХЭЛНЭ.

ЭХ-ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

ДАНСНЫ АВЛАГА

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

МӨНГӨТЭЙ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

МӨНГӨН СУУРЬТ АРГА

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

АККРУЭЛ СУУРЬТ АРГА

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

Өр төлбөр

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

НДШ-НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

ҮАЗ-ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

ОТ-ОРЛОГЫН ТАЙЛАН

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан

ЦА

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээнийн үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

ББӨ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

ОАТ

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

НА

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

МГТ-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

ҮҮАМГ

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ.

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Монгол улс, Улаанбаатар хот 17040,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 48.
Утас: 11-344837
www.apu.mn